



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/58

Tөгөл

**Хагас жилийн мал тооллогыг зохион
байгуулах комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1в 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хагас жилийн мал тооллогыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэл төвлөсөн хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тооллогын ажлын бэлтгэлийг сайтар хангуулж мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, түүвэрт сонгогдсон өрхийн малыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж гарч буй зөрчил дутагдлыг газар дээр нь залруулж холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг тооллогын комиссын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

3. Хагас жилийн мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явцад хяналт тавьж тооллогын явцын мэдээг тухай бүр нь танилцуулж ажиллахыг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Г.Шинэбаяр)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Санхүү албаны дарга (БХишигсүрэн)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

М.ОТГОНБААТАР



/Zahiramj/

Сумын Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 05 ны өдрийн
А/52 дугаар Захирамжийн хавсралт

2024 оны хагас жилийн мал тооллогын ажлыг
зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

М.Батцогт (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: Б.Баярхүү (Шивлэг 1-р багийн Засаг дарга)
Д.Пүрэвдаваа (Тоом 2-р багийн Засаг дарга)
Х.Даваа (Мунгараг 3-р багийн Засаг дарга)
С.Мягмардорж (Соёо 4-р багийн Засаг дарга)
Т.Амарсайхан (Төгөл 5-р багийн Засаг дарга)
Л.Баттогтох (Гун 6-р багийн Засаг дарга)
Н.Намхайбаатар (Хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:
Г.Шинэбаяр (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)